



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/41

Булган сум

Орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар тогтоолын 4 дэх заалт, 2022 оны 469 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх "Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүрэм"-ийг 1 дүгээр, бүтэц, орон тооны дээд хязгаарыг 62 байхаар шинэчлэн тогтоож, 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан орон тооны бүтцийн дагуу дотоод зохион байгуулалт хийж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/164 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь /цаашид "газар" гэнэ/ Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийн дагуу байгуулагдсан аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газрын үндсэн зорилго нь Байгаль орчны хууль тогтоомжийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, ус, цаг уур, орчны шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх, сум дундын ойн ангийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, байгаль орчны сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэхэд оршино.

1.3. Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагууд, Иргэдийн төлөөлөгчийн хурал, Засаг даргын бодлого, тогтоол, шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгон тэднээс мэргэжил арга зүйн удирдамж авч Сав газрын захиргаа, Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай ажлын уялдааг хангаж ажиллана.

1.4. Газар нь аймгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах, арга зүйн удирдлагаар тогтмол хангаж, хэрэглэгчдийг байгаль орчны мэдээллээр хангах экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

1.5. Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага, бүтэц

2.1. Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймгийн Засаг дарга томилно.

2.2. Газрын дарга дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.2.1. Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

2.2.2. Газрын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, ажлын байрны тодорхойлолтыг батлах, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар төрийн захиргааны албан хаагч, ажилтнуудтай үр дүнгийн гэрээ, үйлчилгээний албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ тус тус байгуулж, үр дүнг дүгнэх.

2.2.3. Газрын албан хаагчдыг зохих журмын дагуу томилох, чөлөөлөх, ажилтнуудыг шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх

2.2.4. Батлагдсан төсвийг захиран зарцуулах

- 2.2.5. Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах
- 2.2.6. Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах
- 2.2.7. Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг бүрэн хангах
- 2.2.8. Газрын үйл ажиллагаатай холбогдолтой гарсан хууль, тогтоомж, УИХ, Засгийн газар, яам, агентлаг болон орон нутгийн удирдах байгууллагын тогтоол, тушаал, шийдвэрийг аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлах, хэрэгжүүлэх, төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар зохион байгуулах
- 2.2.9. Сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгах байгаль орчны ажлын чиглэл, шалгуур үзүүлэлтийг сумын онцлогтой уялдуулан боловсруулж, Засаг дарга нарт дэмжлэг үзүүлэх
- 2.2.10. Газрын бүрэлдэхүүнд ойн нэгж ажиллуулах, сум дундын ойн ангийг харьяалах
- 2.2.11. Газрын ажилтнууд, байгаль хамгаалагч нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, давтан сургах, дадлага туршлагажуулахад туслалцаа үзүүлэх
- 2.2.12. Байгаль орчны нөхөрлөлийн ахлагч нарт мэргэжлийн арга зүйн болон бусад чиглэлээр дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах
- 2.2.13. Байгаль орчны салбарын зарим тулгамдсан асуудал бүрээр аймгийн дэд хөтөлбөр санаачлан боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангуулах
- 2.2.14. Сумдын байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу томилох, чөлөөлөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах

Гурав. Газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- 3.1. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа 2050, Улсын Их Хурал, Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын шийдвэрээр батлагдсан байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, "Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр"-т байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах
- 3.2. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын дүрэм журам стандартуудыг мөрдүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих
- 3.3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр аймаг, сум, орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг зохион байгуулах
- 3.4. Аймгийн Засаг даргатай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдсан тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах
- 3.5. Сумдын хэмжээнд хэрэгжүүлэх байгаль орчны арга хэмжээг жил, улирлаар төлөвлөн зохион байгуулж дүгнэх
- 3.6. Байгаль хамгаалагчдыг сонгох, мэргэжлийн удирдлагаар байнга хангаж, тэдний үйл

ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, шагнаж, урамшуулах.

3.7. Байгаль хамгаалагчдыг бие хамгаалах техник хэрэгсэл, унаагаар хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

3.8. Байгалийн болон аялал жуулчлалын нөөц баялгийн талаарх мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн, холбогдох байгууллага, иргэдэд байгаль орчны мэдээллээр үйлчлэх

3.9. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтуудыг жишиг болгон байгаль орчны мэдээллийн улсын сангийн мэдээ, баримтыг бүрдүүлэн Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хуулийн хугацаанд ирүүлж байх

3.10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төслүүдийг үнэлгээнд бүрэн хамруулах, аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хуулийн дагуу эрх үүргийнхээ хүрээнд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийн талаархи тайланг жил бүр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж байх

3.11. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэ ажилд байгууллага, иргэдийн хүч оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

3.12. Нутгийн ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Байгаль орчныг хамгаалах болон аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулан мэргэжлийн ажилчдыг сургах, давтан сургах боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх. Ой, ус, ургамал, ан амьтан зэрэг, байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад зориулсан хялбарчилсан гарын авлага, зөвлөмж боловсруулан нийтийн хүртээл болгох.

3.13. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг авах. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх, түүнд холбогдох талуудын оролцоог хянах ажлыг зохион байгуулах.

3.14. Байгаль орчин, аялал жуулчлалын холбогдолтой судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах

3.15. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмээг нарийвчлан тогтоолгох, тэдгээрийг мөрдүүлж ажиллах

3.16. Ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын захилга, даалгаварт ажлын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, агаар, ус, хөрсийг бохирдлоос хамгаалах, хяналт шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд ус цаг уур орчны шинжилгээний албыг татан оролцуулах, хог хаягдал, химийн бодисын менежментийг хэрэгжүүлэх, ой хээрийн түймрээс сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагад хандах

3.17. Байгаль орчныг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, үүний дотор ойжуулах, ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх, халгүй хаягдалгүй технологи нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тухайн аймагт энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

болон ой, ус, ургамал, ангийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах

Дөрөв. Газрын санхүүжилт

4.1. Газрын санхүүжилт дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

4.1.1. Батлагдсан төсөв

4.1.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хуулиар зохицуулагдах хөрөнгийн тодорхой хэсэг

4.1.3. Газрын өөрийн хөрөнгө, хууль тогтоомжийн хүрээнд явуулсан үйл ажиллагааны орлого

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дүгээр сарын 25-ны өдрийн А/Д/11 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтэц

- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга-1
- Ойн нэгжийн дарга-1
- Мэргэжилтэн-10
 - Усны нөөц, газар, газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн
 - Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, тусгай хамгаалалттай газар нутаг, төрийн бус байгууллагатай ажиллах, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн
 - Ойн ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн
 - Орчны бохирдол, хог хаягдал, химийн хорт бодис, байгалийн гамшиг хариуцсан мэргэжилтэн
 - Биологийн төрөл зүйл, мэдээллийн сан, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
 - Аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Ойжуулалт, нөхөн сэргээлт, ногоон байгууламж, тэрбум мод хариуцсан мэргэжилтэн
 - Ой, ан амьтан хариуцсан хяналтын улсын байцаагч
 - Орчны бохирдол, ус хариуцсан хяналтын улсын байцаагч
- Сумдын байгаль хамгаалагч-40
- Үйлчилгээний ажилтан-10
 - Нягтлан бодогч-1
 - Архив, бичиг хэргийн эрхлэгч-1
 - Нярав, жолооч-1
 - Жолооч-1
 - Үйлчлэгч-1
 - Сахиул-1
 - Галч-4